

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМАНД 2016 ОНЫ  
III УЛИРАЛД ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ  
ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Тус яам, харъяа байгууллага иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх ажиллагааг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” Монгол Улсын хууль, бусад хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж байна.

2016 оны 3-р улирлын байдлаар хүлээн авсан өргөдөл, гомдол, тэдгээрийг шийдвэрлэсэн байдал, зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай мэдээ, танилцуулгыг тогтоосон журам, хугацааны дотор гаргаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн бөгөөд энэ асуудлыг Яамны бүтцийн нэгжүүдийн удирдлагын хуралдаанд танилцуулан дүгнэлт, шийдвэр гаргуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Тус яаманд 2016 оны 3-р улиралд нийт **203** өргөдөл ирсэнээс хуулийн хугацаанд **173** өргөдлийг шийдвэрлэж бусад байгууллагад **55** иргэний өргөдлийг шилжүүлсэн, **67** иргэний өргөдлийг хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн, **30** өргөдөл хугацаа болоогүй байна. Нийт өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн биелэлт **85,2%** хэрэгжилттэй байна.

2016 оны 3-р улиралд хүлээн авч, шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын байдлыг хавсралт 1,2,3-аар тус тус гарган хүргүүлж байна.

ХЭГ-ын 548 тоот албан бичгийн  
нэг, хоёрдугаар хавсралт

**Эрчим хүчний яамны 2016 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс Төрийн захиргааны байгууллагад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт**

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс:				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	Эрчим хүчний яам	203	203	0	0	0	0
Тайлбар: 11-11төвөөс шилжиж ирсэн санал хүсэлтийг тайланд оруулаагүй болно. 2016 оны 11сарын 18-ний байдлаар							

**Эрчим хүчний яамны 2016 оны 3-р улиралд иргэдээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал**

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1	Эрчим хүчний яам	203	173	55	67	30	85.2%

ХЭГ-ын 548 тоот албан бичгийн гуравдугаар хавсралт

### Өргөдөл, гомдол санал хүсэлтийн агуулга

д/д	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал / тоо, нийт өргөдөл гомдолд эзлэх хувь /
1	Эрчим хүчний яам	<p>Нийт 203 өргөдлөөс: Хүсэлт – <b>169 /83,2%</b>  Гомдол – <b>31 /15,2%</b>  Санал – <b>3 / 1,4%</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Ажилд орох, гарах, чөлөө хүсэх тухай төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгаатай холбоотой асуудлаар – <b>112 /55,1%</b></li> <li>- Түлш эрчим хүчний үйлдвэрлэлттэй холбоотой - <b>45 /22,1%</b></li> <li>- Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой – <b>28 /13,7%</b></li> <li>- Бусад асуудлаар- <b>8 /9,1%</b></li> <li>• Эрчим хүчний яам нийслэлийн 6 дүүргийн алслагдсан 1562 өрх айлыг нэг сарын хугацаанд эрчим хүчээр хангаж тогтой болгосон.</li> <li>• Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор 2 тарифт тоолууртай гэр хорооллын айл өрхүүдийн цахилгааны шөнийн тарифийг 50 хувиар хөнгөлөх шийдвэр хэрэгжиж байна.</li> </ul>